



**№3.12.САУНЫ ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦӨЛ, ХАЛДВАР  
ХАМГААЛЛЫН ДЭГЛЭМИЙГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН  
ХУУДАС**

**Хяналтын байгууллага:**

**Шалгуулагч этгээдийн нэр:**

**Объектын нэр:**

**Регистрийн дугаар:**

Хяналт шалгалт хийсэн огноо: .../.../...

Шаардлага хангасан асуултын тоо:

Хууль сахин мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй нийт оноо:

Эрсдэл үүсэх магадлалын хувь:

Эрсдэл үүсэх магадлал

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ**

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй	
1		2	3	4	5
<b>Сауны газрын дотоод хяналт</b>					
1	ТХШТХ-ийн 7.2, Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлуулан мөрдөж ажилладаг	0	5	
2	шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам Засгийн газрын 311 тогтоол	Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлдэг	0	5	
<b>Сауны барилга байгууламжид тавигдах эрүүл ахуйн шаардлага</b>					
3		Эрх бүхий байгууллагаас баталсан зураг төслийн дагуу баригдсан үйлчилгээний шаардлага хангахуйц барилга байгууламжтай байна	0	5	
4		Сауны барилгад сайн чанарын гацуур, шинэс, нарсан материал хэрэглэдэг	0	5	

5		Сауны доторлогоонд 16-22 мм зузаан, 60-120 мм өргөнтэй найлзуурхайгүй, сайтар зүлгүүрдсэн, ямар нэгэн өнгөлөгч болон хамгаалагч бодис түрхээгүй, туршилт эдэлгээнд хэрэглээгүй мод хэрэглэдэг	0	5	
6		Сауны хана, таазыг модоор хэрж хийх бөгөөд хана, тааз уур тусгаарлагчтай	0	5	
7		Сауны ерөөний талбайг нэг хүнд 0.8-1.0 м.кв талбайтай байхаар тооцоолж хийсэн	0	5	
8		Сауны ерөөний хаалганы дээд хэсэгт 0.25 x 0.30 м харьцаатай, татаж нээгддэг салхивчтай	0	5	
9	Эрүүл ахуйн тухай хуулийн 6.2 Саун.Ерөнхий шаардлага MNS 5164:2002	Сауны ерөөний суудал нь шаталсан, суудлын өргөн нь 0.40 м, хэвтэх тавцангийн өргөн нь 0.50-0.60 м-ээс багагүй, суудлын эхний шат нь шалнаас 0.40-0.50 м, дунд шат нь 0.75-0.80 м, дээд шат нь 1.0-1.05 м өндөрт байхаар тооцож хийсэн	0	5	
10		Сауны ерөөний хана, шаланд бэхлэгдсэн, бэхэлгээний хадаас, эрэг, боолт нь биенд хүрэхээргүй далдлагдсан	0	5	
11		Саунд 10 л/мин хүртэл халуун, хүйтэн ус гаргаж шүрших хурдны тохируулагч бүхий шүршүүртэй	0	5	
12		Амралтын ерөөтэй байх ба талбайн хэмжээ 1 цагт үйлчлүүлэгчдийн дундаж тоог 2,0 м.кв-аар үржүүлээд гарсан хэмжээний талбайтай	0	5	
13		Амралт, иллэг, чийрэгжүүлэлтийн ерөөний хана, тааз, шал болон тавилга нь тэгш гадаргуутай, бөх бат, ус нэвтрүүлдэггүй, цэвэрлэхэд хялбар, угаалгын болон халдваргүйжүүлэлтийн бодист тэсвэртэй зориулалтын материалаар хийгдсэн	0	5	
14		Дотоод заслын барилгын материал эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй, шинжилгээнд хамрагдсан баталгаажилттай	0	5	
15		Зөөлөн хэрэглэл, үнэртэн гоо сайхны бүтээгдэхүүн, угаалгын болон халдваргүйжүүлэлтийн бодисыг тус тусад нь хадгалах тавиур бүхий ерөөтэй	0	5	

16		Хэрэглэсэн зөөлөн хэрэглэл, ажилчдын хувцсыг угаах угаалгын өрөөтэй	0	5	
<b>Үйлчилгээний газрын агааржуулалтын систем</b>					
17		Амралт, иллэг, чийрэгжүүлэлт, хүлээн авахын өрөөнүүдэд агаар оруулж, гаргах механик төхөөрөмжтэй	0	10	
18	Эрүүл ахуйн тухай хуулийн 6.2 Саун.Ерөнхий шаардлага MNS 5164:2002	Агаар оруулж, гаргах механик төхөөрөмжийг ажиллуулах цагийн хуваарийг хүчин чадлаас хамаарч тухайн байгууллага гарган мөрдүүлдэг	0	5	
19		Амралт, иллэг, чийрэгжүүлэлт, хүлээн авахын өрөөнүүдийн хэм 18-22 градус, чийглэг 40-60%-иас ихгүй /физик хэмжилт хийнэ/	0	10	
<b>Сауны газрын ус хангамж, ариутгах татуурга</b>					
20	Эрүүл ахуйн тухай хуулийн 4.1.1 Саун.Ерөнхий шаардлага MNS 5164:2002	Сауны газрын ус нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт” MNS 0900:2005 стандартын шаардлага хангасан	0	10	
21	“Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт” MNS 0900:2005	Хэсгийн ус хангамжтай нөхцөлд эх үүсвэрт эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүс тогтоосон	0	5	
22	стандарт	Ундны усны эх үүсвэрийн худаг эрүүл ахуйн шаардлага хангасан барилга байгууламжтай	0	5	
23		Бохир ус зайлуулах бага оврын цэвэрлэх байгууламжтай тохиолдолд зураг төслийн дагуу технологи үйл ажиллагаа бүрэн хийнэ	0	5	
24		Бага оврын цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг хүчин чадлаас хамааруулан стандартын дагуу тогтоосон	0	5	
25	Эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.1 Саун.Ерөнхий шаардлага MNS 5164:2002 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар.Хаягдал ус.Ерөнхий шаардлага MNS 4943:2015	Бага оврын цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир усыг хаях талбайн хөрсийг бохирдлоос хамгаалах арга хэмжээ авсан	0	5	
26		Бохирын цооногтой тохиолдолд цооногийг бетон, төмөр бетон, геомембран болон бусад ус үл нэвчих материалаар доторлосон	0	5	
27		Хоногт 5 шоометрээс их бохир ус хуримтлагдах цэгийн доторлогоог батлагдсан зураг төслийн дагуу хийсэн	0	5	

28		Цэвэрлэх байгууламжтай тохиолдолд цэвэршүүлсэн бохир ус нь стандартын шаардлага хангасан	0	5	
<b>Үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлын шаардлага хангагдсан байдал</b>					
29		Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар мэдээлэл, лавлагааны зориулалтаар сауны өрөө нь дотоод холбоогоор холбогдсон	0	5	
30	Эрүүл ахуйн тухай хуулийн 6.1 Саун.Ерөнхий шаардлага MNS 5164:2002	Үйлчлүүлэгчдийн артерийн даралтыг хэмжих зориулалтаар цусны даралтын аппарат, чагнууртай	0	5	
31		Эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх боломж бүхий эмийн сантай	0	5	
32		Саунд орж болохгүй өвчнүүдийн заалтыг тодоор бичиж нийтэд харагдахуйц газар байрлуулсан	0	5	
<b>Сауны тоноглол</b>					
33	Эрүүл ахуйн тухай хуулийн 6.2 Саун.Ерөнхий шаардлага MNS 5164:2002	Цахилгаан самбарыг сауны гадна талд угсарна. Халаагч нэгж нь сауны өрөөний эзэлхүүний 1 м.куб бүрт 0.6-0.9 KW хүчин чадалтай, хамгийн удаан нь 40 минутанд температурыг 75 градус хүртэл өсгөх шаардлагыг хангасан	0	5	
34		70 хувь хүртэл чийглэг заадаг чийг хэмжигч, 120 градус хүртэл хэмжих термометртэй	0	5	
35		Автоматаар дохио өгөх цагтай	0	5	
<b>Сауны өрөө тасалгааны угаалга, халдваргүйжүүлэлт</b>					
36	Саун.Ерөнхий шаардлага MNS 5164:2002	Сауны болон бусад өрөө тасалгаануудад өдөрт 2-оос доошгүй удаа чийгтэй цэвэрлэгээ хийж, ажил дуусахад халдваргүйтгэлийн бодисын уусмалаар цэвэрлэж халдваргүйжүүлдэг	0	5	
37		Долоо хоногт 1-ээс доошгүй удаа бүх өрөө, тасалгаануудад их цэвэрлэгээ хийдэг	0	5	
38		Үйлчлүүлэгч бүрт нэг удаагийн болон угааж, халдваргүйжүүлсэн хувцас, алчуур, малгай, улавч хэрэглэдэг	0	5	
<b>Лабораторийн шинжилгээтэй хяналт</b>					

39	Саун.Ерөнхий шаардлага MNS 5164:2002	Сауны газрын шүршүүр, хувцасны өрөөнүүдэд байгаа хөлийн гишгүүр мод, резинэн улавч зэрэг эд зүйлсээс авсан эрүүл зүйн бичил амьсудлалын арчдасны шинжилгээгээр эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан	0	10	
<b>Хатуу хог хаягдлын зайлуулалт</b>					
40	Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1	Үйлчилгээний газраас гарах хог хаягдлыг хадгалах хогийн сав хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн	0	5	
41	Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2	Хогийн савыг галд тэсвэртэй материалаар хийсэн	0	5	
42	Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3	Хогийн сав нь хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн	0	5	
43	Эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.1, 4.4.2	Хатуу хог хаягдлыг зайлуулах байгууламж нь /цэг/ гэр, байшин, хүнс боловсруулах, хадгалах газар, хүүхдийн тоглоомын талбайгаас 20-30 метрт, тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зайтай	0	5	
44	Эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.3 Саун.Ерөнхий шаардлага MNS 5164:2002	Өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, ногоон байгууламжийн арчилгааг хийдэг	0	5	
<b>Боловсон хүчний хөгжилд тавих шаардлага</b>					
45	Саун.Ерөнхий шаардлага MNS 5164:2002	Үйлчилгээний газрын ажиллагсад нь тухайн чиглэлээр сургалтанд хамрагдаж мэргэшсэн	0	5	
46		Үйлчилгээний ажилчид тогтоосон хугацаанд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан	0	5	
<b>НИЙТ ОНОО</b>			<b>0</b>	<b>250</b>	<b>0</b>

<b>БАТАЛГААЖУУЛАЛТ</b>		
Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан
/ овоог, нэр/	/ овоог, нэр/	/ овоог, нэр/
/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тамга/

Тайлбар: